



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/15

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн Сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчний хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, малчидтай хариуцлагын гэрээ байгуулах ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумдад ажилласан талаарх мэдээллийг аймгийн Онцгой комисст танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

3. Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийн орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100214

Аймгийн Засаг даргын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн ... дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Хошууч Л.Дорждэрэм (Онцгой байдлын газрын
гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн
байдал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Б.Дашням (Аймгийн Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ-ийн мэргэжилтэн)

Ц.Гэрэл (Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн
албаны дарга)

Д.Бямбадорж (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
мэргэжилтэн)

Цагдаагийн ахмад М.Батболд (Цагдаагийн газар)

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: П.Батбаяр (Онцгой байдлын газрын гал
түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн захирагч)

Гишүүд: Л.Адъяацэрэн (Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн)

М.Батгэрэл (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
мал үржил, ургамал хамгаалал, хорио цээрийн
улсын хяналтын байцаагч)

Цагдаагийн дэслэгч Б.Доржготов (Цагдаагийн газар)

Аймгийн Засаг даргын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн ... дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Явах км	Шатахууны төрөл	Нэ бүрийн үнэ	Хэмжээ	Нийт үнэ
1	1 дүгээр ажлын хэсэг	900	Дизел түлш	3960	220	871,200
2	2 дугаар ажлын хэсэг	800	АИ-92	3960	160	633,000
Нийт үнэ: 1,504,600						